**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймаг дахь Хөгжил политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/057/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: М.Энхжаргал<br>Утас:70432545 Цахим хаяг: enkhjargalm@audit.gov.mn |

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 10
3.1 Төлбөрийн акт ........ 10
3.2 Зөвлөмж ........ 11
**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 13
**5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл ........ 14**

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| МУЗГ | Монгол улсын засгийн газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| *ХАБЭА* | Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуй |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.03 № 41

танай ______-ны №______-т

ХОВД АЙМАГ ДАХЬ
ХӨГЖИЛ ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
Д.БАЯРМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймаг дахь Хөгжил политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг**

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээгээр 98.3 % тай I түвшинд үнэлэгдэж 229.1 мянган төгрөгийн урамшуулал авч салбарын хэмжээнд 6 дах удаа тэргүүлсэн амжилт гаргасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 429,193.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Ховд аймаг дахь Хөгжил политехник коллеж нь 2025 оны 4 сард Ази, Номхон Далайн бүсийн (АРАСС) чанарын баталгаажилтын байгуулаагаар үнэлүүлэн 6 жилийн хугацаатай магадлан итгэмжлэл алтан өргөмжлөл авсан байна.

8426050041

2025-2026 оны хичээлийн жилд 21 чиглэлийн 32 хөтөлбөрөөр нийт 1029 суралцагч элсэн суралцаж, элсэлтийн хувь 102.4%-д хүрч, элсэлтийн тоо нэмэгджээ.

2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлт 99.8 хувьтай үнэлэгдсэн байна .

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **254,536,579.32** | **227,603,326.09** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 54,852,242.90 | 62,103,377.07 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 54,852,242.90 | 62,103,377.07 |
| **3121** | **Төгрөг** | 54,852,242.90 | 62,103,377.07 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 54,852,242.90 | 62,103,377.07 |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 2,155,490.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 2,155,490.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 2,155,490.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 5,470,000.00 | 00.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 5,470,000.00 | 00.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 5,470,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 194,214,336.42 | 163,344,459.02 |
| **351** | **Түүхий эд материал** | 100,177.00 | 00.00 |
| 35130 | Эм боох материал | 100,177.00 | 00.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 9,669,350.00 | 1,410,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 135,999,809.42 | 116,809,459.02 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,083,500.00 | 738,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,262,570.00 | 8,235,960.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 243,550.00 | 130,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 38,500.00 | 42,371.00 |
| 35460 | Хүнсний материал | 14,825,695.40 | 15,083,725.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 106,545,994.02 | 92,579,003.02 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 00.00 | 00.00 |
| 35600 | Мал амьтад | 48,445,000.00 | 45,125,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,619,042,137.99** | **10,511,729,268.02** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 10,619,042,137.99 | 10,511,729,268.02 |
| **392** | **Биет хөрөнгө** | 8,092,336,637.99 | 7,974,812,029.02 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 8,734,939,900.26 | 9,043,215,230.26 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,534,908,955.61 | -1,854,610,115.33 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 49,011,728.47 | 78,011,728.47 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -49,011,728.47 | -60,514,009.51 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 3,797,714,133.79 | 3,831,266,133.79 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -3,072,482,152.10 | -3,262,602,351.03 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 345,928,575.74 | 394,082,772.74 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -309,799,832.27 | -324,982,328.55 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,174,871.80 | 6,174,871.80 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -134,871.80 | -134,871.80 |
| 39217 | Ном | 124,904,968.18 | 124,904,968.18 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 2,526,705,500.00 | 2,536,917,239.00 |
| 39301 | Програм хангамж | 30,095,017.84 | 30,095,017.84 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -30,095,017.84 | -30,095,017.84 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,526,705,500.00 | 2,536,917,239.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **10,873,578,717.31** | **10,739,332,594.11** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **7,106,909.22** | **127,169,330.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 7,106,909.22 | 127,169,330.00 |
| **413** | **Өглөг** | 7,106,909.22 | 127,169,330.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 16,775,342.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 3,194,859.22 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 3,912,050.00 | 110,393,988.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3,912,050.00 | 101,980,088.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 8,413,900.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **10,866,471,808.09** | **10,612,163,264.11** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 10,866,471,808.09 | 10,612,163,264.11 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 5,198,672,137.00 | 5,198,672,137.00 |
| 51101 | Өмч:  - төрийн | 5,198,672,137.00 | 5,198,672,137.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,173,384,563.43 | 3,919,076,019.45 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,173,384,563.43 | 4,173,384,563.43 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -254,308,543.98 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,494,415,107.66 | 1,494,415,107.66 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **10,873,578,717.31** | **10,739,332,594.11** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **7,851,342,804.00** | **8,439,246,900.93** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **706,459,704.00** | **703,078,052.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 593,124,371.00 | 703,078,052.93 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 593,124,371.00 | 703,078,052.93 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 295,579,106.00 | 96,011,588.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 52,372,070.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 297,545,265.00 | 554,694,394.93 |
| **122** | **Тусламжийн орлого** | 113,335,333.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 113,335,333.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **7,144,883,100.00** | **7,736,168,848.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 6,508,310,200.00 | 6,882,146,980.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 6,508,310,200.00 | 6,882,146,980.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 636,572,900.00 | 843,932,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 636,572,900.00 | 843,932,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 10,089,068.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 10,089,068.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **8,251,323,057.13** | **8,693,555,444.91** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,251,323,057.13** | **8,693,555,444.91** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 7,716,970,322.58 | 8,293,676,601.67 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,303,359,913.00 | 4,861,998,428.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,206,742,139.00 | 3,012,858,260.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,666,067,902.00 | 1,541,266,559.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 130,045,905.00 | 121,248,684.00 |
| 210104 | Урамшуулал | 300,503,967.00 | 186,624,925.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 526,135,206.60 | 588,069,445.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 335,533,156.97 | 402,705,216.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 69,479,498.16 | 50,584,458.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 22,688,150.94 | 26,247,620.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 19,855,009.22 | 21,853,164.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 78,579,391.31 | 86,678,985.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 788,884,767.67 | 810,030,767.54 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 61,174,340.67 | 64,036,881.54 |
| 210302 | Түлш, халаалт | 604,962,977.00 | 567,139,276.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 122,747,450.00 | 178,854,610.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 179,194,586.50 | 154,770,166.25 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,349,450.00 | 8,537,594.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,516,720.00 | 56,402,130.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,036,150.50 | 8,154,749.75 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 22,540,016.00 | 13,678,828.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 30,987,250.00 | 17,278,190.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 45,765,000.00 | 35,485,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 15,233,673.50 |
| **2105** | **Нормативт зардал** | 167,715,665.60 | 273,983,207.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,083,143.00 | 2,420,927.00 |
| 210502 | Хоол, хүнс | 149,506,522.60 | 271,562,280.90 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 13,126,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 45,918,350.00 | 65,040,240.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,059,100.00 | 1,205,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 24,489,850.00 | 34,462,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,369,400.00 | 29,371,940.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 40,664,745.00 | 37,510,153.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 9,051,573.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 40,664,745.00 | 28,458,580.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 73,113,823.00 | 198,989,246.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,501,500.00 | 69,389,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 30,570,823.00 | 124,411,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 1,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 1,362,640.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,130,000.00 | 2,680,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 812,500.00 | 124,406.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,591,983,265.21 | 1,303,284,947.55 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 363,634,709.10 | 116,965,692.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 684,728,175.00 | 658,315,400.65 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 543,620,381.11 | 528,003,854.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 534,352,734.55 | 399,878,843.24 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 529,852,732.00 | 393,171,670.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 10,089,068.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 238,588,732.00 | 92,848,602.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 277,264,000.00 | 283,170,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 14,000,000.00 | 7,064,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,500,002.55 | 6,707,173.24 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,500,002.55 | 6,707,173.24 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-399,980,253.13** | **-254,308,543.98** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-399,980,253.13** | **-254,308,543.98** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,198,672,137.0** | **1,494,415,107.66** | **4,173,384,563.43** | 10,866,471,808.09 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,198,672,137.0** | **1,494,415,107.66** | **4,173,384,563.43** | 10,866,471,808.09 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.0 | 00.00 | -254,308,543.98 | -254,308,543.98 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,198,672,137.0** | **1,494,415,107.66** | **3,919,076,019.45** | 10,612,163,264.11 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **7,553,797,539.00** | **7,884,552,506.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **408,914,439.00** | **148,383,658.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 295,579,106.00 | 148,383,658.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 295,579,106.00 | 148,383,658.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 295,579,106.00 | 96,011,588.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 52,372,070.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 113,335,333.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 113,335,333.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **7,144,883,100.00** | **7,736,168,848.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 6,508,310,200.00 | 6,882,146,980.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 6,508,310,200.00 | 6,882,146,980.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 636,572,900.00 | 843,932,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 636,572,900.00 | 843,932,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 10,089,068.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 10,089,068.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **7,498,945,296.10** | **7,836,149,371.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,498,945,296.10** | **7,836,149,371.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,964,592,561.55** | **7,435,485,528.59** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,302,159,913.00 | 4,824,520,916.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,198,273,389.00 | 2,479,935,216.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,673,336,652.00 | 2,035,427,067.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 130,045,905.00 | 133,265,186.00 |
| 210104 | Урамшуулал | 300,503,967.00 | 175,893,447.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 526,135,206.60 | 589,959,370.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 362,210,009.79 | 405,723,123.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 42,802,645.28 | 48,679,591.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 22,688,150.94 | 26,087,123.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 19,855,009.28 | 21,851,667.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 78,579,391.31 | 87,617,863.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 627,572,897.45 | 813,225,626.76 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 57,979,481.45 | 67,231,740.76 |
| 210302 | Түлш, халаалт | 446,845,966.00 | 567,139,276.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 122,747,450.00 | 178,854,610.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 156,954,450.00 | 221,983,140.00 |
| 210502 | Хоол, хүнс | 156,954,450.00 | 221,983,140.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 62,919,900.00 | 66,400,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 58,419,900.00 | 42,400,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,500,000.00 | 24,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 172,715,511.00 | 193,304,240.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 172,715,511.00 | 193,304,240.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,116,134,683.50 | 726,091,735.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 561,560,476.50 | 328,260,427.75 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 554,574,207.00 | 397,831,307.65 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **534,352,734.55** | **400,663,843.24** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 529,852,732.00 | 393,956,670.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 10,089,068.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 238,588,732.00 | 92,848,602.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 277,264,000.00 | 283,170,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 14,000,000.00 | 7,849,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,500,002.55 | 6,707,173.24 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,500,002.55 | 6,707,173.24 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **54,852,242.90** | **48,403,134.17** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **41,152,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 41,152,000.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **(41,152,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 54,852,242.90 | 7,251,134.17 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 54,852,242.90 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 54,852,242.90 | 62,103,377.07 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 7,977,146,503.00 | 7,860,505,130.59 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 7,977,146,503.00 | 7,860,505,130.59 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 7,593,278,901.00 | 7,476,637,528.59 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,853,133,900.00 | 4,824,520,916.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,358,607,600.00 | 2,479,935,216.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,319,254,000.00 | 2,035,427,067.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 175,272,300.00 | 133,265,186.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 175,893,447.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 600,342,400.00 | 589,959,370.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 404,318,000.00 | 405,723,123.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 49,006,100.00 | 48,679,591.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 24,503,100.00 | 26,087,123.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 24,503,100.00 | 21,851,667.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 98,012,100.00 | 87,617,863.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 819,932,900.00 | 813,225,626.76 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 63,031,500.00 | 67,231,740.76 |
| 210302 | Түлш, халаалт | 620,776,400.00 | 567,139,276.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 136,124,000.00 | 178,854,610.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 248,126,101.00 | 221,983,140.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 248,126,101.00 | 221,983,140.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 66,400,500.00 | 66,400,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 42,400,500.00 | 42,400,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,000,000.00 | 24,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 240,161,700.00 | 203,004,240.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 240,161,700.00 | 203,004,240.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 765181400.00 | 757543735.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 361,650,100.00 | 354,012,427.75 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 403,531,300.00 | 403,531,307.65 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 383,867,602.00 | 383,867,602.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 383,867,602.00 | 383,867,602.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 101,033,700.00 | 92,848,602.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 283,170,000.00 | 283,170,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,600,000.00 | 7,849,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 7,977,146,503.06 | 7,922,608,507.66 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 6,929,977,802.16 | 6,882,146,980.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 6,929,977,802.16 | 6,882,146,980.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 843,932,800.00 | 837,225,626.76 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 843,932,800.00 | 837,225,626.76 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 148,383,658.00 | 148,383,658.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 96,011,588.00 | 96,011,588.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 52,372,070.00 | 52,372,070.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 54,852,242.90 | 54,852,242.90 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 62,103,377.07 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 00.00 | 00.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 00.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 120.00 | 125.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 04.00 | 04.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 88.00 | 91.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 28.00 | 30.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00.00 | 00.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1,029.00 | 1,029.00 |
| **632** | **МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ** | 1,029.00 | 1,029.00 |
| 632001 | Төрийн өмчит МСҮТ | 1,029.00 | 1,029.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **120.00** | **125.00** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,558.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 18,517.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа [1] -г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Малын нас дэвшлээс 1,000.0 мянган төгрөгийн 10 хонийг данс бүртгэлд тусгаагүй
- Хувь хүний орлогын албан татварын өрийг 2,438.8 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн
- Тайлант хугацааны үр дүнг 1,482.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн
- Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодсон, үндсэн хөрөнгийг капиталжуулахдаа буруу данс сонгосон 13,595.9 мянган төгрөг

Залруулагдаагүй 4,041.6 мянган төгрөгийн 3 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4,041.6 мянган төгрөгийн 3 зөрчил [2] илэрснээс, 2,656.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд байгууллагын удирдлага нь санхүүгийн ажилтнуудын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон боловч тус урамшуулалтай давхардуулан сургуулийн захирлын 2025 оны 09 дүгээр

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

сарын 24 өдрийн Б/108 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 2,656.6 мянган төгрөгийн урамшуулал илүү олгоод буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.2.1 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт Сургуулийн балансад бүртгэлтэй малын үнэ зах зээлийн үнээс бага байгаа зөрчил илэрсэн нь НББОУС-41, НББОУС-2, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” стандарттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Малын үнийг шинэчлэн тогтоох саналыг байгууллагын өмч хамгаалах зөвлөлд танилцуулж, зах зээлийн бодит үнэ цэнээр үнэлэх

#### 3.2.2 Албан томилолттой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд албан томилолтоор ажилласан хүмүүст унаа хоолны мөнгө давхцуулан олгосон 1,385.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь МУЗГ-ын 6 дугаар тогтоолд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр унааны зардал, байрны зардал, хоолны зардал зардлаас бүрдэнэ, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.2-т " Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, түүний хэмжээг Засгийн газар тогтооно", гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдаас илүү олгосон томилолтын зардлыг суутган авч, алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| **Алдааны утга** | **Нийт алдаа** | | **Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан** | | **Буруу тусган илэрхийлсэн** | | **Үүнээс:** | | | | **Зөвлөмж** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Залруулсан** | | **Залруулаагүй** | | | |
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **тоо** | **Дүн** | **тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Малын нас дэвшлийг дутуу бүртгэж орлого аваагүй | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодсон, үндсэн хөрөнгийг капиталжуулахдаа данс буруу сонгосон | 1 | 13,595.9 | 1 | 13,595.9 | | | 1 | 13,595.9 | | | | |
| Өр төлбөр, тайлант хугацааны үр дүн зөрүүтэй тооцсон | 2 | 3,921.4 | | | 2 | 3,921.4 | 2 | 3,921.4 | | | | |
| | **4** | **18,517.3** | **2** | **14,595.9** | **2** | **3,921.4** | **4** | **18,517.3** | | | | |

*4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* */мянган төгрөгөөр/*

| **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс:** | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн** | |
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Балансt бүртгэлтэй малын үнэ зах зээлийн үнээс зөрүүтэй | 1 | - | | | | | 1 | - | | |
| Албан томилолтоор ажилласан хүмүүст унаа хоолны мөнгө давхцуулан олгосон | 1 | 1,385.0 | | | | | 1 | 1,385.00 | | |
| Балансын урамшуулал, үр дүнгийн нэмэгдлийг давхардуулан олгосон | 1 | 2,656.6 | 1 | 2,656.6 | | | | | | |
| | **3** | **4,041.6** | **1** | **2,656.6** | **0** | **0** | **2** | **1,385.0** | **0** | **0** |

4.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал * /мянган төгрөгөөр/*

| **Аудитад хамрагдсан байгууллагын нэр** | **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс:** | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | |
| | | | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Ховд аймаг дахь хөгжил политехник коллеж | Алдаа зөрчил илрээгүй | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нийт дүн** | | **0** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| | | | | | | | | | |

## 5.ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |